



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 224

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 30,000,000.00 (гучин сая) төгрөгийн балансын үнэ, 6,500,000.00 (зургаан сая таван зуун мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, “Барилгын хөгжлийн төв” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Ц.Амарсанаа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

 Д.НАРАНГЭРЭЛ

132005553

17-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2023 оны 06 дугаар сарын 08 ны өдрийн  
108 дугаар тогтоолын хавсралт

**"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,  
БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Ландкрузер-200, 08-29 УНУ, JTMHV05J504115742	2013/2014	30,000,000.00	6,500,000.00	23,500,000.00
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>30,000,000.00</b> (гучин сая)	<b>6,500,000.00</b> (зургаан сая таван зуун мянга)	<b>23,500,000.00</b> (хорин гурван сая таван зуун мянга)